

мэдэгдсэн тухайгаа заавал баримтжуулна.

Шийдвэр гүйцэтгэгч шийдвэр гүйцэтгэх ажиллагааг үүсгэсний дараа төлбөр авагчийн хүсэлтийг үндэслэн төлбөр төлөгчөөс түүний өмчлөлийн болон төлбөр төлөгчийн өмчлөлийн хөрөнгө бусдын эзэмшилд байгаа, эсхүл ирээдүйд бий болох бусад эд хөрөнгийн тухай тухай мэдүүлгийг авна.

Төлбөр төлөгч нь эд хөрөнгийн тухай мэдүүлэг авах талаар мэдэгдсэнээс хойш долоо хоногийн дотор үнэн зөв мэдүүлэх, хөрөнгийн байдалд орсон аливаа өөрчлөлтийн талаар төлбөр төлөгч шийдвэр гүйцэтгэгчид нэн даруй мэдэгдэж байх үүрэгтэй бөгөөд түүний ирээгүй нь уг мэдүүлгийг авахад саад болохгүй.

Эд хөрөнгийн тухай мэдүүлэг өгөхөөс зайлсхийсэн эсвэл худал мэдүүлэг өгсөн нь эрүүгийн хариуцлага тооцуулахаар Цагдаагийн байгууллагад хандах үндэслэл болно.

* * *



Б.ЭРДЭНЭ-ОЧИР

Шүүхийн шийдвэр
гүйцэтгэлийн
сургуулийн Иргэний
болон захиргааны
ШШГЭЗ-ийн тэнхимийн
ахлах багш, ахмад

ТӨЛБӨР ТӨЛӨГЧ ИРГЭНИЙ ХАЯГЖИЛТ

Манай улсын нийт хүн амын 56,5 хувь нь хотод, 43,5 хувь нь хөдөөд амьдарч байна.

Улаанбаатар хот нь шилжилт хөдөлгөөн ихтэй, гадаадын иргэн, оюутан, улирлын чанартай ажилчид, цэргийн алба хаагч, түрээсийн байранд амьдардаг иргэд, байр хөлслөгч нэг үгээр хэлбэл нийт хотын иргэдийн 35 хүртэл хувийг түр оршин суугчид эзэлдэг байна. Мөн орон байрны боломжоос шалтгаалан нэг байр, хашаанд аав ээжтэйгээ нийлээд хэд хэдэн өрх айл амьдрах нь хэвийн үзэгдэл юм.

Иргэний бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлд зааснаар ...“Иргэн аливаа засаг захиргааны нэгжид 180 хоногоос дээш хугацаагаар оршин суухдаа 10 хоногийн дотор холбогдох сум, дүүргийн улсын бүртгэлийн асуудал хариуцсан нэгж, ажилтанд оршин суугаа газрынхаа хаягийн бүртгэлийг иргэний үнэмлэхэд тэмдэглүүлхээр заасан байдаг. Гэвч ихэнхи иргэд иргэний үнэмлэх дээрх заасан хаяг дээр амьдардаггүй, шилжилт хөдөлгөөнөө тэмдэглүүлдэггүй тул гүйцэтгэх баримт бичигт заасан хаягт төлбөр төлөгч байхгүй байх тохиолдол их байдаг байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 13 дугаар зүйлд зааснаар “Төлбөр төлөгч иргэн бол шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түүний оршин суугаа нутаг дэвсгэрийн тойргийн шийдвэр гүйцэтгэгч гүйцэтгэхээр” заажээ. Шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа тойргийн журмаар явагдан нэг тойргийн шийдвэр гүйцэтгэгч нөгөө тойрогт үйл ажиллагаа явуулах эрхгүй байдаг. Төлбөр төлөгч иргэний оршин суух хаяг нь доорх байдлаар тодорхойгүй болдог байна. Үүнд:

1. Тухайн хаяг дээр оршин суудаг боловч хороондоо бүртгэлгүй
2. Тухайн хаяг дээр оршин суудаггүй боловч хороондоо бүртгэлтэй
3. Түр оршин сууж байгаад хаяг тодорхойгүй нүүсэн

Гэр хорооллын мухар гудамж, эмх замбараагүй хатгасан хашаа, хайс, гуу, жалга, гэрэлтүүлэггүй гудамжаар шөнө орой явж хаяггүй, задгайд амьдарч байгаа айл хайх нь шийдвэр гүйцэтгэгчийн хамгийн хүндрэлтэй, цаг зав, шатахуун барж байдаг хүндрэлтэй асуудал байдаг. Шийдвэр гүйцэтгэгч өдөрт дунджаар хаяг нь тодорхой 5 айлд очиж амждаг бол зарим үед нэг ч айл олохгүй тохиолдол байдаг байна. Хорооноос хүн амын болон өрхийн бүртгэл, сонгогчдын нэрсийн жагсаалт гаргах, элдэв халамж, хүүхдийн мөнгө, тэтгэвэр тэтгэмж олгох ажлын хврээнд гэр хорооллын задгай хэсгийг хаягжуулах, хаягийг шинэчлэх ажил хийгддэг. Цагдаа, онцгой, түргэн тусламжийг иргэд өөрсдөө дуудлага өгдөг, тосох үйлчилгээ үзүүлдэг бол шийдвэр гүйцэтгэгч заавал өөрөө явж олох шаардлагатай байдаг. Хөгжилтэй хотожсон орнуудын тухайд бүх зүйл хаягжилттай холбоотой.

Одоогийн байдлаар Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулдаг 17500 гаруй байгууллагын дөнгөж 1700 орчим нь, орон сууцны хорооллуудын 25000 гаруй барилгад 5000 хаяг байршуулхаас 3700 орчим нь хаягтай, гэр хороололд нийт 77474 хашаа байдгаас 13560 хашааны хаяг бичиг нь танигдахаа больж нар, салхинд гандсан, 9629 хашаа ямар ч хаяггүй буюу задгайд амьдарч байна. Өнгөрсөн 2014 онд 50,0 сая төгрөгөөр шинээр нэрлэгдсэн 50 гудамжинд 1072 төгрөгийн самбар, 48.0 сая төгрөгөөр 11200 айлын хашааны хаалганы самбар, гэр хорооллын 628 гудамжны нэрийн хаягийн самбар, гэр хорооллын 514 гудамжны дугаарын хаягжилтийг хийж гүйцэтгэсэн байна.

Нийслэлээс гэр хорооллыг хаягжуулах талаар дараах хөтөлбөр төслийг хэрэгжүүлж байгаа бөгөөд үүнд Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх алба зохих хэмжээнд хамрагдах, хамтран ажиллах, үр шимийг нь хүртэх шаардлагатай байна. Үүнд:

1. Баянзүрх дүүргийн 27, 21, 10 дугаар хороо, Баянгол дүүргийн 9, 16, Сонгинохайрхан 3, 27 дугаар хороо, Сүхбаатар дүүргийн 14 дүгээр хороо, Чингэлтэй дүүргийн 12,16, 17 дугаар хороо зэрэг нийт 16 байршилд түр уулзах цэг байгуулсан. Тус цэгээс гэр хорооллын иргэд өөрсдийн хэрэглээний мэдээллийг авч байна. Тухайлбал, гурван самбарын нэг талд иргэд бусдад түгээх зар, мэдээлэл байршуулах, нөгөө талд нь хороодын хэсэг байршил, гудамж, дугаар, зохион байгуулалт зэргээс очих айлдаа яаж очиж болох мэдээлэл, гурав дахь самбарт яаралтай үед иргэдэд зориулагдсан лавлах утасны дугааруудыг байршуулаад байгаа. Тиймээс тус цэг нь гэр

хорооллын айл өрхүүдийн хашааны хаягжилт тодорхойгүй, мухар гудамжтай байдгаас түргэн тусламж, гал команд, цагдаа, онцгой байдлын албаныхан иргэдэд төрийн үйлчилгээг цаг алдалгүй хүргэхэд хүндрэл үүсдэг асуудлыг шийдэх нэг гарц болж байгаа юм. Шийдвэр гүйцэтгэгч энэ цэгээс төлбөр төлөгчийн талар шаардлагтай мэдээллийг авах боломжтой.

2. Мэдээлэл, харилцаа холбооны нэгэн шийдэл нь шуудангийн үйлчилгээ юм. Манай улс шуудангийн үйлчилгээ үзүүлдэг боловч одоо хэр нь хаягжилтийн стандартгүй, өрх бүрт тодорхой хаягжилт хийгдээгүй байна. Тэгвэл Засгийн газраас 2020 он хүртэл хэрэгжүүлэх "Өрх бүрт шуудан" хөтөлбөрийн хүрээнд олон улсад идэвхтэй хэрэглэгддэг, дэлхийн стандартад нийцсэн шуудангийн үйлчилгээг нэвтрүүлэх гэж байна. Өрх бүрт шуудан" хөтөлбөр нь 2015 он гэхэд хаягжилтийн системтэй болно. Ингэснээр өрх бүр өөрийн гэсэн шуудангийн хаягтай болж, өөрт хэрэгцээтэй мэдээллийг өөрийн хаягаар авах бололцоо, нөхцөл бүрдэнэ. Энэ нөхцөлд шийдвэр гүйцэтгэгч төлбөр төлөгчийн хаягаар харьцах бүрэн боломжтой болно.

Шийдвэр гүйцэтгэгч өөрийн хариуцсан тойргийнхоо талаарх судалгааг сайтар хийх нь ажиллагааг шуурхай явуулах үндэс болно. Жишээ нь : Тухайн хороо хэдэн аж ахуйн нэгжтэй, хүн ам, төрийн байгууллага, сургууль, цэцэрлэг, амьжиргааны түвшин, хорооны газрын зураг, задгай хэсэг, холбогдох утас гэх мэт. Мөн хорооны нийгмийн ажилтан, хэсгийн ахлагч, өрхийн эмнэлэг, цагдаагаас төлбөр төлөгчийн талаарх мэдээллийг авах хэрэгтэй. Ялангуяа

нийгмийн ажилтан, хэсгийн ахлагч нартай холбоотой ажиллах шаардлагтай. Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх алба шийдвэр гүйцэтгэлийн зардлын сангаас хамтран ажиллаж байгаа хороо, ажилтанг урамшуулдаг системийг нэвтрүүлэх хэрэгтэй байна.

* * *

